

Эрүүл мэндийн газрын даргын
2019 оны 11 дүгээр сарын 18-ны
өдрийн 14 тоот тушаалын
хоёрдугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

☐

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн
боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газар

Нэгжийн нэр:

Эдийн засаг, удирдлага, төлөвлөлтийн
хэлтэс

Албан тушаалын нэр:

Хэлтсийн дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:


Эрүүл мэндийн салбарын болон бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, нутаг дэвсгэрийн хэмжээнд бүртгэгдсэн халдварт өвчний байдалд дүгнэлт хийх, тандалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж, нэгжийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган, гүйцэтгэлийн үр дүнг Эрүүл мэндийн газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт


- 1.Эрүүл мэндийн салбарын болон бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хянах, тайлагнах.
- 2.Эмнэлгийн ажилтан, иргэд, олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгаа хийх, мэргэжил арга зүйн зөвлөмж, лавлагаа өгөх, халдварт өвчин, түүнд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийн чиглэлээр тандалт судалгаа, үнэлгээ хийж, эрсдлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах.
- 3.Хэлтсийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах.
- 4.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм журам, стандартыг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх–Ш
1дүгээр зорилтын хүрээнд	1.Халдварт өвчний талаар гарсан Монгол улсын хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах;	Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2.Харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг дархлаажуулалт, халдварт өвчний чиглэлээр мэргэжлийн удирдлага, үйл ажиллагааны нэгдсэн бодлого чиглэлээр хангаж ажиллах	Хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байна.	Х,Т
2 дугаар зорилтын хүрээнд	1.Халдварт өвчний хяналт урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрүүл мэндийн үйлчилгээний бүх шатанд зохион байгуулах ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтийг зохицуулах;	Эрүүл мэндийн үйлчилгээний бүх шатлал чадавхижсан байна.	

2.Амьсгалын замын халдварт өвчний чиглэлээр хэрэгжиж буй тогтоол, тушаал, заавар, журмыг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах;	Амьсгалын замын халдварын хариу арга хэмжээний хэрэгжилт хангагдсан байна.	Г,Х,Т
3.Халдварт өвчний чиглэлээр хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн батлуулж, холбогдох байгууллагуудыг мэргэжлийн арга зүйгээр хангах, хэрэгжүүлэх, тайлагнах;	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байна. Мэргэжил арга зүйгээр хангасан байгууллагууд чадавхижсан байна.	Г
4.Элэгний В, С вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэн эрүүлжүүлэх, тархалтыг судлах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах;	В,С вирусын илрүүлэг, хяналт, эмчилгээний хамрагдалтын хувь нэмэгдсэн байна.	Г
5.Халдварт өвчний талаар мэдээллийн сан байгуулах, баяжуулах ажлыг зохион байгуулах;	Халдварт өвчний эргэн мэдээлэл сайжирсан байна.	Г,Х,Т
6.Халдварт өвчин, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах;	Тушаал шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
7.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах үйл ажиллагаанд орон нутгийн удирдлага, шийдвэр гаргагч нарын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх ухуулга,	Шийдвэр гаргагч нарын оролцоо сайжирсан байна.	



	нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж, оролцоог нэмэгдүүлэх;			
	8.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах үйл ажиллагаанд төрийн болон ТББ, аж ахуйн нэгж, гэр бүл, иргэний оролцоо, хамтын ажиллагааг сайжруулах;	Халдварт өвчний хариу арга хэмжээний хэрэгжилт хангагдсан байна.		Г,Х,Т
	9.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны материал боловсруулах, нийтэд түгээх;	Хүн амын мэдлэг, хандлага дээшилсэн байна.		Г,Х
	10.Эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтнүүд, иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах;	Эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтнүүд чадавхижсан байна.		Г
	11.Сургууль, цэцэрлэгийн орчинд амьсгалын замын халдварт өвчин дэгдэх эрсдэлийг судалж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дэглэмийн хэрэгжилтэнд үнэлгээ, дүгнэлт хийж, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх.	Сургууль цэцэрлэгийн орчмын халдварт өвчин гарах эрсдэл буурсан байна. Эрсдлийн үнэлгээний дүнд үндэслэн төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт хангагдана.		Г,Х
3 дугаар зорилтын хүрээнд	1. Хэлтсийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган, мэргэжилтнүүдийг мэргэжлийн арга зүй, зөвлөмжөөр хангаж, дадлагажуулах замаар төрийн үйлчилгээний стандартыг мөрдүүлэх, харилцааны соёл, хандлагыг сайжруулах;	Мэргэжилтнүүд чадавхижиж, төрийн үйлчилгээний стандарт хангагдана.		Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Төрийн албаны стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөж ажиллах;	Ёс зүйн зөрчил гаргасан эсэх. Ёс зүйн		



		дүрмийн хэрэгжилт хангагдана.		
	2.Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.	Ашиг сонирхлын зөрчил гаргасан эсэх.		Г
	3.Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;	Хэрэгжилтийн хувь.		Г
	4.Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг гүйцэтгэх, эргэн мэдээлэх;	Биелэлтийн хувь.		Г
	5.Байгууллага, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, биелэлтийг тайлагнах;	Хэрэгжилтийн хувь.		Г
	6.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх, биелэлтийг тайлагнах;	Хэрэгжилтийн хувь.		Г
	7.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хэрэгжилтийн хувь.		Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	Анагаах ухаан /0912/, эдийн засаг /0311/, нягтлан бодох бүртгэл /041101/, эрх зүй /042/, менежмент ба удирдахуй /0413/.		
Мэргэшил	Төрийн албаны мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх.		
Туршлага	Дэс түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил эсхүл төрийн албанд 4-өөс доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэлийг цаг тухайд нь үнэлдэг байх; - нэгжийн албан хаагчдын ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, адил тэгш хандаг;	



		- нэгжийн үйл ажиллагаан дахь эрсдлийг урьдчилан тодорхойлох, илрүүлэх, авах арга хэмжээний төслийг боловсруулах, танилцуулах; - албан хаагчдын сургалт хөгжлийн асуудалд идэвхитэй дэмжлэг үзүүлж, тасралтгүй суралцагч байгууллага болох соёлыг төлөвшүүлэх; - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - бусад.	
	Дүн шинжилгээ хийх	- аливаа асуудлын талаар бүрэн ойлголт авахын тулд шаардлагатай мэдээллийг цуглуулах, үнэлэх, тайлбарлах; - хоорондоо шууд хамааралгүй нөхцөл байдлын байж болох уялдаа холбоог тодорхойлдог байх; - болзошгүй үр дагаврыг урьдчилан таамаглаж, үйл ажиллагааны боломжит хувилбарыг төлөвлөдөг байх; - мэдээлэлд тулгуурлан чиг үүргийн болон системийн шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа хийх; - судалгааны дүн, мэдээлэлд тулгуурлан бодлого боловсруулах; - судалгааны үр дүн, шийдлийн хувилбарын шууд ба шууд бус үр дагаврыг харьцуулан үнэлж, зөвлөмж боловсруулах; - бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах; - бусад.	
	Асуудал шийдвэрлэх	- хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - аливаа харилцааг зохицуулах арга замыг хууль, тогтоомжийн төсөлд санал өгөх; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд - асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - шийдвэрийг гаргахдаа хамт олны саналыг - тусгадаг байх; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.	
	Манлайлах	- ёс зүйн хэм хэмжээг сахих; - нэгжийн үйл ажиллагаанд шинэлэг санаа, дэвшилтэт арга барил, үйлчилгээг нэвтрүүлэх, чиглүүлэх, албан хаагчдын шинэ санаачлага, бүтээлч сэтгэлгээ, хандлагыг дэмжих; - байгууллага, нэгжийн үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх; - гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа хамт олны саналыг тусгах, үр дүнд чиглүүлэх;	



		- өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх; - нээлттэй, шударга байх; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх; - зарчимч, тууштай, ажил хэрэгч байх; - бусад.
	Бусад	- албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - шаардлагатай хэрэглээний программ хангамжийг эзэмшиж, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэн ажиллах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - багаар ажиллах, багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах; - харилцааны орчин үеийн арга хэлбэрийг ашиглан мэдээллийг түгээх.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Эрүүл мэндийн газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Мэргэжилтнүүд – 12

Бусад харилцах субъект:

- Эрүүл мэндийн байгууллагуудын дарга нар;
- Эмнэлгийн ажилчид;
- Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох ажилтан;
- Эрүүл мэндийн яамны холбогдох мэргэжилтэн;
- Эрүүл мэндийн хөгжлийн төвийн холбогдох мэргэжилтнүүд;
- Иргэн, хуулийн этгээд, төрийн бус байгууллагын холбогдох ажилтан.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ЭДИЙН ЗАСАГ, УДИРДЛАГА
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Баасандорж Д.БААСАНДОРЖ


2019 оны 11 дугаар сарын 04 ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 19 11 02

Дугаар: 278



Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

ХЭНТИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо: ...2019-11-18...

Дугаар: 617...

ДАРГА



Ц.ГЭРЭЛМАА

2019 оны 11 дугаар сарын 18-ны өдөр

-----oOo-----

